



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/605

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Хөхий уулын хишиг” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Нүүдлийн авто зам засвар /Мянгад сум/-ын 1 дүгээр багц ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б. Ганзориг - Мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын улсын байцагч

Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга

С.Өнөржаргал - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Ч.Баатар - Мянгад сумын Засаг дарга

Б.Эрдэнэзаяа - “Хөхий уулын хишиг” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2.

2. “Хөхий уулын хишиг” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Нүүдлийн авто зам засвар /Мянгад сум/-ын 1 дүгээр багц ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН